

**“НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ
АВТО БААЗ” УТҮГ**



БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

1.1.Байгууллагын бүтэц, орон тоо

Байгууллагын бүтэц, орон тоо нь Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагддаг бөгөөд хамгийн сүүлд 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Нийслэлийн Засаг даргын А/995 дугаар захирамжаар тус байгууллагын бүтэц, орон тооны хязгаар шинэчлэгдэж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/614 захирамжаар байгууллагын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсан. Үүнд:

Хэлтэс		Орон тоо
1	Дарга	1
Захиргаа, хүний нөөцийн хэлтэс		9
1	Хэлтсийн дарга	1
2	Эрх зүйн асуудал хариуцсан ажилтан	1
3	Хүний нөөцийн ажилтан	1
4	Мэдээлэл технологи, архив бичиг хэргийн ажилтан	1
5	Үйлчилгээний ажилтан	1
6	Манаач	4
Санхүү, төлөвлөлтийн хэлтэс		3
1	Хэлтсийн дарга	1
2	Эдийн засагч, нягтлан бодогч	1
3	Техникч-нярав	1
Тээвэр, зохицуулалтын хэлтэс		92
1	Хэлтсийн дарга	1
2	Ашиглалтын инженер	1
3	Механик инженер	1
4	Диспетчер-механик	8
5	Үйлчилгээний жолооч	78
6	Механик засварчин	2
7	Сантехникч	1
Хэлтэс 3, нийт албан хаагчийн тоо 105.		Нийт 105

1.2.Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/995, 2025 оны А/614 дүгээр захирамжаар Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ нь дараах чиг үүргийг гүйцэтгэхээр дүрэмд заасан. Үүнд:

1.	Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан, байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд ажил үйлчилгээний гэрээ байгуулан, байгууллагуудад автомашинаар үйлчлэх.
2.	Үйлчилгээнд яаж байгаа авто тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, стандарт, норм, нормативыг мөрдөж, шуурхай чирэгдэлгүй үйлчлэх.
3.	Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хуульд заасны дагуу санхүүгийн анхан шатны бүртгэлийг хөтөлж, тайлан балансыг зохих хугацаанд гаргах.
4.	Байгууллагын инженер, техникийн ажилтнуудыг мэргэжлийн өндөр боловсролтой, дадлага туршлагатай боловсон хүчнээр бэлжүүлэх, жолооч нарын боловсрол, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх талаар арга хэмжээ авах.

5.	Авто үйлчилгээнд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, буруутай үйлдлийг илрүүлж, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, учирсан хохирлыг арилгуулах, жолооч нарын ангилал дээшлүүлэх, сургах мэргэшүүлэх, хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах
6.	Шатахуун, тослох материал, автомашины сэлбэг, дулаан, цахилгаан, усны үнэ нэмэгдэхэд үйлчилгээний үнэ тарифыг өөрчлөх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар бусад холбогдох газруудтай хамтран боловсруулан Нийслэлийн Засаг даргад танилцуулан, шийдвэрлүүлж, мөрдөж ажиллах

ХОЁР. АВТО ТЭЭВРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Тээврийн хэрэгсэл, засвар үйлчилгээний мэдээлэл

Нийслэлийн Төр захиргааны авто баяз УТҮТ-ын үйлчилгээнд явж байгаа тээврийн хэрэгслүүдийн аюулгүй байдал, стандарт, норм, нормативыг мөрдөж, шуурхай чирэгдэлгүй үйлчлэх ажлын хүрээнд Тойота камри, Тойота сиенна, Ланд крузер 300, Тойота хайс зэрэг нийт 47 тээврийн хэрэгслээр парк шинэчлэлт хийсэн бөгөөд байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй насжилт өндөртэй, цаашид дуудлагын үйлчилгээнд ашиглах шаардлага хангахгүй 34 тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт шилжүүлсэн.



2025 оны хэмжээнд ТҮ-1, ТҮ-2 техник үйлчилгээг тээврийн хэрэгслүүдэд графикийн дагуу хийж, техникийн үзлэг оношилгоонд 133 тээврийн хэрэгслийг бүрэн хамруулсан. Мөн энэ оны хэмжээнд давхардсан тоогоор 116 тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээ хийсэн бөгөөд зуны ТҮ-д 47, өвлийн ТҮ-д 66 тээврийн хэрэгслийн тос масло, маслоны шүүр, салоны агаар шүүгч, зөөлны агаар шүүгч сольж 7 тээврийн хэрэгслийг кузов засварт оруулсан.



Байгууллагын нийт хөдлөх бүрэлдэхүүнийг Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/15 захирамжийн 1.4.3 дахь заалтын дагуу техникийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд 2025 онд нийт 133 тээврийн хэрэгслийг үзлэг оношилгоонд 100% бүрэн хамруулсан.



Үйлчилгээний соёл, чанар, стандартыг ханган ажиллах, диспетчер механикийн ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс ахлан жилийн эцсийн байдлаар хуваарийн дагуу ажлын байрны шалгалтыг нийт 22 удаа хийсэн.

Шалгалтаар илэрсэн зөрчлийг дор бүр арилгуулж, цаашид анхаарч ажиллах, үйлчилгээний жолооч нарын хувцаслалт, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, өнгө үзэмж дээр анхаарч ажиллах чиглэл өгсөн.



2.2.Байгууллагын тээврийн хэрэгслийн насжилт, парк ашиглалтын үзүүлэлт


Тээврийн хэрэгслийг үйлдвэрлэсэн оноор нь жагсаан насжилтын судалгааг гаргасан бөгөөд график үзүүлэлтээр харьцууллаа. Үүнд:

Тээврийн хэрэгслүүдийн насжилтийн судалгаа




➤ Байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг ангилах

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН МАРК




Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1037 дугаар захирамж, 2023 оны А/940 дүгээр түр захирамжаар Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний хүрээнд Замын хөдөлгөөнд тэгш сондгой улсын дугаараар оролцох чиглэлийн дагуу дугаарын хязгаартай өдрүүдэд тээврийн хэрэгслүүдийг үйлчилгээнд гаргахгүй байх ажлыг зохион байгуулснаар ПАК-ийн дундаж үзүүлэлт 2024 онд 85% болж буурсан үзүүлэлттэй байсан бол 2025 онд 85,3% болж өссөн байна.

Парк ашиглалтын коэффициентийн харьцуулалт



2.3. Дуудлага үйлчилгээний зохицуулалт



2025 оны 12 дугаар сарын 20-ны байдлаар нийт 94 тээврийн хэрэгслээр 64 байгууллагын 92 хэрэглэгчдэд болон хөдөө орон нутагт, гадаад дотоодын зочид төлөөлөгчдэд нийт 1,162,000 км зам явж үйлчилсэн байна. Энэ нь 2024 оныхтой харьцуулбал 307,000 км-ээр илүү явсан байна. Тайлант хугацаанд хэрэглэгч байгууллагаас ирсэн 1469 гаруй дуудлагад тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлсэн байна.



Дуудлагын автомашин захиалгын систем 2025 онд нийт 1469 захиалга авсан ба үүнээс системээр 1146 захиалга, утсаар 323 захиалга авч ажил үйлчилгээнд гаргасан байна. Захиалагч байгууллагуудын санаачилгаар 89 захиалга цуцлагдсан байна.



2025 оны жилийн эцсийн байдлаар "Улаанбаатар марафон-2025" олон улсын гүйлтэд оролцсон гадаад, дотоодын тамирчид, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн бизнес инновацийн газар, Нийслэлийн бодлогын судалгаа шинжилгээний газар, Чингэлтэй дүүргийн Иргэдийн хурал, Сүхбаатар дүүргийн Иргэдийн хурал, төсөл нэгжүүдийн зочны үйлчилгээнд тээврийн хэрэгслийн үйлчилгээг үзүүлэн ажилласан.

- Зочин болон дуудлагын үйлчилгээнд гарч буй тээврийн хэрэгслүүдийн бэлэн байдлыг хангаж цэвэрлээд үйлчилгээг тогтмол хийж байна.



ГУРАВ. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Санхүүгийн тайлан, орлого, зарлага

Санхүү төлөвлөлтийн хэлтэс нь байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад эдийн засаг, санхүүгийн чиг үүргийг хэрэгжүүлэн, төсөв, санхүүг хугацаанд нь үр ашигтай зөв захиран зарцуулан, "Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль", "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг", Санхүүгийн үйл ажиллагааны журам болон бусад холбогдох дээд газруудаас гарсан шийдвэр хууль, дүрэм журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон удирдлагыг бодит мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. Манай хэлтэс бүтцийн хувьд хэлтсийн дарга, оронхий нягтлан бодогч, эдийн засагч-нягтлан бодогч, техникч-нярав гэсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн бүхий л ажил үйлчилгээг гүйцэтгэж байна.

2024 оны жилийн эцсийн болон 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланг тайланг хугацаанд тайлагнан Сангийн яам, Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийслэлийн татварын газар, Бүхбаатар дүүргийн Татварын хэлтэс, Нийгмийн Аалтгалын хэлтэс, Нийслэл дэх төвийн аудитын газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газарт тус тус цаасан болон цахим хэлбэрээр тайланг бэлтгэн гаргаж баталгаажуулан ажилласан.

3.1.1. Тайлан

2025 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээг Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст сар бүр 5-ны өдрийн дотор, дуудлагын автомашины үйлчилгээ үзүүлсэн төлбөрийн баримтыг татварын албаны Ebarnt

цахим системд сар бүрийн 21-25-ны өдрийн дотор, шилэн дансны тайланг сар бүрийн 7-ны өдрийн дотор, нийгмийн даатгалын тайланг сар бүрийн 5-ны өдрийн дотор, цалин хөлсний тайланг хуулийн хугацаанд тус тус тайлагнан ажилласан.

2024 оны жилийн эцэс болон 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланг дараах байдлаар холбогдох газруудад хуулийн хугацаанд тайлагнан ажилласан. Үүнд:

Сангийн яамны и-баланс



Засгийн газрын төсвийн гүйцэтгэлийн Э-Тайлан: Төсвийн нэгдсэн тайлан.

Э-ТАЙЛАН

Хүснэгт: 1. Төсвийн нэгдсэн тайлан

Байгууллага: УБ Нийслэлийн арга барил

Тайлан: 2024

Төрөл	СЭТ	НЭТ	НЭТ	НЭТ	НЭТ	Төсвийн	Өмчлөх өмч	Эзэмшүүлсэн	Эзэмшүүлсэн өмч
1-р төрөл	✓	✓	✓	✓	✓	✓	2024.01.01	Нийслэлийн арга барил	2024.01.01
2-р төрөл	✓	✓	✓	✓	✓	✓	2024.01.01	Нийслэлийн арга барил	2024.01.01
3-р төрөл	✓	✓	✓	✓	✓	✓	2024.01.01	Нийслэлийн арга барил	2024.01.01
4-р төрөл	✓	✓	✓	✓	✓	✓	2024.01.01	Нийслэлийн арга барил	2024.01.01

✓ - Ой шалбарсан
 / - Шалбарсан
 ✗ - Шалбарсан
 ✗ - Шалбарсан
 ✗ - Шалбарсан
 ✗ - Шалбарсан

➤ Татварын албаны цахим татварын систем




Үйл ажиллагааны орлого төсвийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрддэг. 2025 оноос 100% төсөвт байгууллагын статуст шилжин нийт 1,302.8 сая төгрөгийн үйл ажиллагааны орлогыг төвлөрүүлэн ажиллахаар төсөөлөгдсөн. 2025 оны эхний хагас хагас жилийн байдлаар дараах гүйцэтгэлтэй байна.

2025 оны орлогын төлөвлөгөөний харьцуулалт (сая.төг)

Д/д	Орлого	2025 оны төлөвлөгөө	2025 оны жилийн эцсийн төлөвлөгөөний биелэлт	Төлөвлөгөөний биелэлтийн (хувь)
1.	Үндсэн үйл ажиллагааны орлого	1,302.8	771.7	59.2%
2.	Төсвийн санхүүжилт	3,238.4	1,882.8	58.1%

Үндсэн үйл ажиллагааны орлого 771.7 сая төгрөг, төсвийн санхүүжилт 1,181.3 сая төгрөг, өөрийн орлогын төлөвлөгөө 37.2% гүйцэтгэлтэй ажиллаж байна. Нийт орлого 1,710.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

Үйл ажиллагааны орлогыг 2024 оны хагас жилтэй харьцуулан үзэхэд:



Төсвийн санхүүжилт 59.3% болж өссөн нь Цалин хөлсний шатлалын доод хэмжээ шинэчлэгдэн нэмэгдсэнтэй холбоотой, үйл ажиллагааны орлого 45.9%-иар өссөн нь Нийслэлийн дүүрэг, агентлагуудын дуудлагын автомашины захиалгын үйлчилгээ нэмэгдэж парк ашиглалтын хэмжээ өссөнтэй холбоотой байна.

3.1.3. Үйл ажиллагааны зарлагын тухай

2025 оноос байгууллагын үйл ажиллагааны санхүүжилтийн зохицуулалт 100% төсөвт харьяалагдаж өөрийн орлого болон төсвөөс санхүүжин, Төрийн сан дахь бүртгэлийн дансаар батлагдсан төсвийн хүрээнд орлого, зардлыг хийн ажиллаж байна.

➤ Үндсэн үйл ажиллагааны зардал

Үзүүлэлт	2025 оны төлөвлөгөө	2026 оны гүйцэтгэл	Гүйц (төл) хэмнэлт, хэтрэлт (+/-)	
			сая.төг	Хувь
Нийт зардлын дүн	4,795.2	4,726.3	68.9	98.5%
Цалин хөлс шагнал	2,983.1	2,983.1	0	100.0%
Нийгмийн даатгалын шимтгэл	548.3	548.3	0	100.0%
Байр ашиглалттай холбоотой зардал	400.9	395.9	4.9	98.7%

Хангамж бараа материалын зардал	47.8	46.9	0.7	98.5%
Эд хогшлын урсгал засварын зардал	168.2	168.2	0	100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	51.7	49.4	2.3	95.6%
Тээвэр шатахууны зардал	456.1	456.1	0	100.0%
Бусад зардал	139.3	78.4	60.9	56.3%
Батлагдсан орон тоо	105	105	0	100%

Батлагдсан төсөө, орон тооны дагуу төсвийн санхүүжилтийг сар бүр авч дотоод журамд зөвсн дагуу 10, 25-ны өдрүүдэд ажилтан албан хаагчдын цалин хөлсийг тосцон олгож, үндсэн үйл ажиллагаатай холбоотой зардлыг батлагдсан төсвийн дагуу үр ашигтай захиран зарцуулан ажилласан.

Тайлант хугацаанд нийт төсвийн 98.5%-ийн гүйцэтгэлтэй, бусад зардалд тусгагдсан өндөр насны тэтгэвэрт суух албан хаагчид олгох нэг удаагийн тэтгэмжийн зардал 47.5 сая төгрөг, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 15.5 сая төгрөгийн тэтгэмжийн зардлыг тус тус зарцуулан ажилласан. 2025 оны төсвийн жилд 60.9 сая төгрөг тэтгэмжийн зардал, байр ашиглалттай холбоотой 4.9 сая, хангамжийн зардалд 0.7 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 2.3 сая төгрөгийн зардлуудыг хэмнэн төсөвт төвлөрүүлэн ажилласан байна.

3.2.Ил тод байдал

Нийслэлийн Засаг даргын 2015 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/01 дүгээр "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" захирамжийн 1 дэх заалтад "Нийслэлийн төсвийн байгууллага, өмчит үйлдвэрийн газрын 2015 оны Санхүүгийн жилийн анхны дансны гүйлгээ хийгдэх хугацаанаас эхлэн шилэн дансны мэдээллийг холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж, ажиллахыг Нийслэл, дүүргийн бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай" гэж зөвсн дагуу хийх ажлын төлөвлөгөө гарган батлуулж Шилэн дансны тухай хууль, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, стандарт, журмын дагуу холбогдох мэдээллийг байршуулж ажиллаж байна. 2025 онд нийт 171 мэдээлэл байршуулахаас 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 66 мэдээллийг байршуулан 38.6% биелэлттэй ажиллаж байна.



Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны статус өөрчлөгдөн төсөвт шилжин өөрчлөгдсөнтэй холбоотой санхүүгийн программыг шинэчлэх шаардлагатай болсон. Төсөв байгууллагын үйл ажиллагаанд нийцсэн "Санхүүгийн тооцоолох групп ХХК"-ийн Аксолус-4.0 программыг 2025 оны 01 дүгээр улиралд амжилттай нэвтрүүлэн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.

Төсвийн жилд батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр өгөөжтэй зарцуулах, төсвийн зардлыг хамнах, орлогын төлөвлөгөөг биелүүлэх, батлагдсан төсвийн хүрээнд зардлыг хэтрүүлэхгүй норм нормативыг баримтлан, өмчийн ашиглалтыг сэйжруулан хууль, дүрам, журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Олон нийтийн үйл ажиллагаа

"Тэрбум мод" Үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 10, 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдрүүдэд буюу "БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР"-ийг тохиолдуулан "Нийслэлийн Төр захиргааны авто бааз" УТҮГ-ын хамт олон Хан-Уул дүүргийн Айцын аманд тарьсан модоо усалж, арчиллаа.



"Улаанбаатар Марафон" Олон улсын гүйлтийн арга хэмжээнд манай байгууллага нь 2017 оноос хойш жил бүр тасралтгүй оролцож байгаад бөгөөд 2025.05.24-ний өдөр зохион байгуулагдсан "Улаанбаатар Марафон" олон улсын гүйлтийн арга хэмжээнд анх удаа 21 км зайд 2 албан хаагч оролцсоноороо онцлог байгаа. 10 км зайд 3 албан хаагч, 5 км зайд 2 албан хаагч нийт 7 албан хаагч амжилттай оролцсон.



4.2. Байгууллагын дэргэдэх зөвлөл, комисс, бригадын үйл ажиллагаа

Байгууллагын зүгээс "Эх үрсийн баяр"-ыг тохиолдуулан нийт ажилтан, албан хаагчдын 168 хүүхдэд бэлэг гардуулсан.



Мөн 2025 онд 1 дүгээр ангид шинээр элсэн орж байгаа 5 албан хаагчийн хүүхдүүдэд хичээлийн хэрэгсэл гардуулсан.

Автотээврийн 100 жилийн ой, Авто тээвэрчдийн өдрийг тохиолдуулан байгууллагын Хүндэтгэлийн хурлыг 2025.07.09-ний өдөр Яармагийн Хангарди ордны хурлын танхимд зохион байгуулж, автотээвэр төрийн үйлчилгээний салбарт олон жил ажиллаж гавьяаны авралтандаа суусан өндөр настан, ажилтан албан хаагчдыг Төр засгийн дээд шагнал, салбарын шагнал, нийслэлийн шагналаар тус тус шагнаж урамшуулсан.



Байгууллагын ажилтан, албан хаагчдын спортын идэвх сонирхлыг дэмжих зорилгоор "Байгууллагын спортын өвэргэ шалгаруулах 5 төрөлт тэмцээн"-ийг 2025.10.25-ны өдөр зохион байгуулсан.



Байгууллагын ажилтан, албан хаагчдын тайлангийн хурлыг 2025.12.27-ны өдөр Хангарди ордны хүндэтгэлийн танхимд зохион байгуулж, байгууллагын цаашдын ажиллах чиглэл, төлөвлөгөөг батлах тухай санал солилцлоо.



4.3. Сургалт семинар

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Чадавжуулах" сургалтуудад дараах албан хаагчид хамрагдсан. Үүнд:

- ХАБ инжэнэр Ц.Энхкаргал ERP системийн хэрэглээ

- Эдийн засагч, тооцооны нягтлан Т.Бадамдагий MS EXCEL дунд шат
- Албан хэргийг хос бичгээр хөтлөх, архивын нэгж бүрдүүлэх нэртэй сургалтад Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга М.Болормаа, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Үүрцэйх, Мэдээлэл технологи, архив бичиг хэргийн ажилтан Ц.Дэлгэрмаа, Хүний нөөцийн ажилтан Д.Сонинзаяа ХАБ инженер Ц.Энхжаргал, Ашиглалтын инженер Ц.Оюунцэцэг, Техникч нярав Х.Нандинцэцэг, Эдийн засагч, тооцооны нягтлан Т.Бадамдагий нар хамрагдсан.
- ТАХ-ийн ёс зүйн тухай хууль, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь- Эрх зүйн асуудал хариуцсан ажилтан М.Тарваа
- Монгол бичгийн цахим бичвэр- Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга М.Болормаа, Санхүү төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Үүрцэйх, Мэдээлэл технологи, архив бичиг хэргийн ажилтан Ц.Дэлгэрмаа, Хүний нөөцийн ажилтан Д.Сонинзаяа, Ашиглалтын инженер Ц.Оюунцэцэг, ХАБ инженер Ц.Энхжаргал, Эдийн засагч, тооцооны нягтлан Т.Бадамдагий, Техникч нярав Х.Нандинцэцэг Захиргааны бүх албан хаагчид хамрагдсан.
- ТАХ-ийн ажлын зохион байгуулалт, харилцааны соёл- Хүний нөөцийн ажилтан Д.Сонинзаяа
- Мониторингийн хяналт, үр дүнгийн үнэлгээ байгууллагын хяналтын тогтолцоо, зохион байгуулах арга, анхаарах зарим асуудлууд- Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга М.Болормаа
- Төрийн байгууллагын хүний нөөцийн мэдээллийг Power BI дашбоардад шилжүүлэх аргачлал- Хүний нөөцийн ажилтан Д.Сонинзаяа
- Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх- ХАБ инженер Ц.Энхжаргал, Техникч нярав Х.Нандинцэцэг нар
- "Алсын хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлогын сургалт Эрх зүйн асуудал хариуцсан ажилтан Б.Дулмаа тус тус хамрагдсан.

Мөн үйлчилгээний жолооч Х.Арилдий №0008469, Б.Ариунболд №0013432, Б.Галаа №0018620, Э.Энх-Амар №0008435, Б.Сүхбаатар №64656 нар Мэргэшсэн зэргийн үнэмлэхийн хугацааг сунгуулсан. Мөн Үйлчилгээний жолооч Т.Нэргүй, Д.Одбаяр, О.Сүх-Эрдэнэ нар "В" ангиллын мэргэшсэн зэргийн сургалтад хамрагдсан байна. Байгууллагын нийт жолооч нарын 56 жолооч мэргэшсэн буюу 76% нь мэргэшсэн байна.



Хүний нөөцийн ажилтан Д.Сонинзаяа, Эрх зүйн асуудал хариуцсан ажилтан Б.Дулмаа нар 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр албан хаагчдад "Технологи ашиглан үйлдэгдэж буй жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх" талаар сургалт хийсэн.

Мөн Монгол улсын Засгийн газар, Жендерийн үндэсний хороо хамтран зохион байгуулсан "Харилцан хүндэтгэе" аяны хүрээнд үйлчилгээний жолооч, механик засварчин нарт Жендерийн эрх тэгш байдлын талаар анхан шатны мэдлэг мэдээлэл олгох зорилгоор цахимаар Жендерийн талаарх тест бөглүүлсэн.

Тайланг 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэст илгээсэн.

Онцгой байдлын Ерөнхий газраас иргэдад гамшгаас өөрийгөө болон бусдын амь насыг явран хамгаалахад сургах зорилгоор жил бүр гамшгийн зарлан мэдээллийн дуут дохиогоор дадлага сургуулилт явуулдаг. Энэ хүрээнд өнөөдөр буруу 2025.03.27-ны өдрийн 16:00 цагт "Нийслэлийн төр захиргааны авто бааз УТҮГ"-ын ажилтан, албан хаагчид дадлага сургуулилтад идэвхтэй хамрагдсан.



Санхүү төлөвлөлтийн албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэхээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн хэлтсээс "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдыг чадавхжуулах байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах", Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэг агентлаг Нийслэлийн татварын газраас зохион байгуулж байгаа татвар төлөгчдийн өдрүүд 2025 оны 05 дугаар сарын 05-аас 05 дугаар сарын 09-ний өдөр хүртэл зохион байгуулсан "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, тайлан завсарлах, албан татвар ногдох, орлого"-ын талаарх сургалтад тус бүр хамрагдсан.

4.4. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх.



Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэгтэй Эрүүл мэндийн багц шинжилгээ хийлгэх гэрээ хийж, 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 06 дугаар сарын 03-ны өдрийн хооронд байгууллагын 105 ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн багц шинжилгээнд хамруулсан.

- Үйлчилгээний жолооч Ч.Гантөмөрийн төрсөн эцэг нас барсан тул Б/22 дугаар тушаалаар 1.5 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
- Манаач Н.Нямаагийн төрсөн ах нас барсан тул Б/23 дугаар тушаалаар 1.5 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
- Диспетчер-механик Ч.Нарантуяагийн төрсөн эцэг нас барсан тул Б/26 дугаар тушаалаар 1.0 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
- Үйлчилгээний жолооч З.Батчулуун Төрийн дээд шагнал "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-гоор, Б.Галаа, Н.Даваажаяа нар Төрийн дээд шагнал "Алтангадаас одон"-гоор шагнагдсан тул Б/35 дугаар тушаалаар хүндэтгэл үзүүлэн 2,160,000 төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
- Үйлчилгээний жолооч А.Баттулгын төрсөн дүү нас барсан тул Б/39 дугаар тушаалаар 0.5 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
- Үйлчилгээний жолооч Л.Баясгаланцогт нь өндөр насны тэтгэвэрт гарсан тул Б/43 дугаар тушаалаар хүндэтгэл үзүүлэн 700,000 төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
- Диспетчер-механик Л.Бат-Эрдэнэ нь Төрийн дээд шагнал "Цэргийн гавьяаны улаан тугийн одон"-гоор шагнагдсан тул Б/44 дүгээр тушаалаар хүндэтгэл үзүүлэн 700,000 төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
- Үйлчилгээний жолооч С.Баатарсүхийн төрсөн эцэг нас барсан тул Б/45 дугаар тушаалаар 1.0 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
- Үйлчилгээний жолооч З.Батчулуун нь өндөр насны тэтгэвэрт гарч байгаа тул Б/53 дугаар тушаалаар хүндэтгэл үзүүлэн 700,000 төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
- Ашиглалтын инжэнэр Ц.Оюунцэцэгийн төрсөн ах нас барсан тул Б/54 дугаар тушаалаар 0.5 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
- Ерөнхий инжэнэр Ч.Энхсүйханы төрсөн ах нас барсан тул Б/38 дугаар тушаалаар 0.5 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.

- Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга М.Болормаа нь хагалгаанд орж, эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон тул Б/65 дугаар тушаалаар 1.5 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
 - Ахмад настан Б.Намсрай нас барсан тул ар гэрт нь мөнгөн тусламж үзүүлж Б/65 дугаар тушаалаар 0.5 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
 - Үйлчилгээний жолооч Б.Ариунболд нь зүрхэнд гуурс суулгах мэс засалд орсон тул Б/76 дугаар тушаалаар 0.5 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
 - Манаач Ж.Санжаагийн эхнэр нас барсан тул Б/79 дүгээр тушаалаар 0.5 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
 - Үйлчилгээний жолооч Б.Ариунболд нь нас барсан тул ар гэрт нь мөнгөн тусламж олгох тухай Б/83 дугаар тушаалаар 3.5 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
 - Манаач Н.Буяннэмэхийн эхнэр нас барсан тул Б/114 дүгээр тушаалаар 1.0 сая төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
 - Үйлчилгээний жолооч Ж.Отгонбаяр нь Төрийн дээд шагнал "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-гоор шагнагдсан тул Б/153 дугаар тушаалаар 700,000 төгрөгийн буцалтгүй тэтгэмж олгосон.
- Нийт 19 албан хаагчдад нийт 19 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмж олгосон.

Нийт 19 албан хаагчдад нийт 19.6 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, тэтгэмж олгосон. Мөн байгууллагын ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийн үзлэгт 7.0 сая төгрөг зарцуулсан.

2025 онд ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд нийт 26.6 сая төгрөгийг зарцуулан ажилласан байна.

4.5.Нийгмийн хариуцлагын хүрээний ажил

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын албан хаагчид Сонгинохайрхан дүүргийн 23 дугаар хорооны айл, өрх, аж ахуйн нэгж байгууллагын галлагвааны аюулгүй байдалд шалгалт хийж, зөвлөгөө, зөвлөмж өгөн ажиллалаа.



2025 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Бүх нийтийн их цэвэрлэгээний хүрээнд байгууллагын гадна талбай, авто машины зогсоол, нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдлыг цэвэрлэлээ.



Нийслэлийн Засаг даргын 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн "Хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах зарим арга хэмжээний тухай" А/354 дүгээр захирамж, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 01/320 тоот албан бичгийн хэрэгжлтийг хангах зорилгоор Нийслэлийн "Төр захиргааны авто база" УТҮГ-ын албан хаагчид их цэвэрлэгээний ажлын удирдамжид заасан хувиарийн дагуу нийтийн эзэмшлийн гудамж, яам талбайн хог хаягдлыг цэвэрлэж, идэвхтэй оролцсон



4.6 Өргөдөл, гомдлын талаар

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэй холбоотой мэдээлэл

Нийслэлийн Төр захиргааны авто база УТҮГ-ын "Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам"-ын хэрэгжилтийг хангаж, иргэдээс ирүүлсэн өргөдөл хүсэлтийг тухай бүрт www.erp.ulaanbaatar.mn программд, хугацаанд нь бүрэн шийдвэрлэж ажиллалаа.

2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 99 өргөдөл хүсэлт ирснийг программд бүртгэн, 99 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.

www.erp.ulaanbaatar.mn өргөдөл гомдлын системд бүртгэсэн 97 өргөдөл бүртгэж, 1800-1200 дугаарын операторын утсанд 1 гомдол, 11-11 төвөд ирсэн 1 гомдол ирснийг холбогдох албан хаагчдад шилжүүлж, шийдвэрлэсэн. Үүнд:

1. Хүсэлт-97

- ✓ Байгууллагын албан хаагчид-67

- ✓ Иргэд-30
- 2. Гомдол-2
 - ✓ Байгууллагын албан хаагчид-1
 - ✓ Иргэд-1 ирсэн байна.
- Хүснэгт-1 Өргөдөл шийдвэрлэлтийн дундаж хугацаа


Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа	Хоног	Цаг	Минут	Нийт өргөдөл, гомдол
	3	16	33	99

2025 ОНЫ ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 23-ны өдрийг хүртэлх хугацаанд манай байгууллагад ирсэн нийт 99 өргөдөл, гомдлыг "Өргөдөл, гомдлын нэгдсэн программ"-д бүртгэсэн байна.


Өнгөрөгч 2024 оны жилийн эцсийн байдлаар 105 өргөдөл, гомдол хүлээн авч хууль зүйн үндэслэлтэй шийдвэрлэсэн байна.

2024-2025 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг графикаар харьцуулсан.



2025 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг (диаграмм-2) Захиргаа хүний нөөцийн хэлтэс 87, Санхүү, төлөвлөлтийн хэлтэс 12, байгууллагын хэмжээнд нийт 99 өргөдөл гомдлоос журмын дагуу хуулийн үндэслэлтэй 99 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байна.

2025 оны өргөдөл, гомдлын хандалтын тайлан



(2025 оны жилийн эцэс)

2025 оны жилийн эцсийн байдлаар хандалтаараа тэргүүлж байгаа 4 асуудал нь ажилд орох хүсэлт 33 (33.57%), ажлаас чөлөөлөгдөх тухай 20 (20.41%), нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай 18 (18.37), цалин, хөлсний тухай 16 (16.33%) ирсэн байна.

Өргөдөл, гомдлын программд нийт 99 өргөдлийг бүртгэж, 99 өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хариуг журмын дагуу 5 хоногт 80 (82.47%), 10 хоногт 8 (8.25%), 15 хоногт 5 (5.15%), 30 хоногт 5 (4.12%).

2025 оны жилийн эцсийн байдлаар хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй болно. Өргөдөл, гомдлын индексээр (PCI) 0.87 буюу "B" үнэлгээтэй байна.

4.6.Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар

Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу байгууллагад хандаж ирсэн 144, явсан нийт 116 бичиг байна.

Байгууллагын хэмжээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийтээр дагаж мөрдөх, цаг үеийн шинэ чанартай болон байгууллагын үйл ажиллагаатай холбогдолтой захирамжлалын баримт бичгүүд Засгийн газрын 1 тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж 7, Нийслэлийн засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл, албан даалгавар, зөвлөмж нийт 2 тус тус холбогдох заалтыг хэрэгжүүлэн баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнаж, хяналт тавин ажиллаж байна.

НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТУГ-ЫН БАРИМТ БИЧГИЙН ЭРГЭЛТИЙН ЖАГСААЛТ

2025 оны 12 дугаар сарын 23

Улаанбаатар хот

№	Баримт бичгийн нэр	2024 оны жилийн эцэс	2025 оны жилийн эцэс
1	Тогтоол	2	1
2	Захирамж	6	7
3	Албан даалгавар, тушаал, зөвлөмж	2	2
4	Даргын А тушаал	49	20
5	Даргын Б тушаал	140	156
6	Ирсэн бичиг: нийт Хариутай бичиг Хариугүй бичиг	228 58 170	306 67 239
7	Төлөөлөгөө	12	12
8	Тайлан, биелэлт	12	12
9	Өргөдөл, гомдол	100	99
10	Явуулсан бичиг:	279	310
11	Хурлын тэмдэглэл нийт: Захиргааны албан хаагчдын Даргын зөвлөлийн Ур чадварын нэмэгдэл Шуурхай хурал Шагналын Өмч хамгаалах	73 36 10 12 0 6 9	37 21 12 0 5 1
12	Гэрээ: Дуудлагын автомашинаар үйлчлэх гэрээ Үр дүнгийн гэрээ Хөдөлмөрийн гэрээ Эд хөрөнгийн гэрээ хариуцлагын	193 53 1 19 120	126 78 1 19 87
13	Дүгнэлт	64	14

Албан хэрэг хөтлөлтийн eDoc.ub.gov.mn

2025 оны жилийн эцсийн байдлаар Захиргаа хүний нөөцийн хэлтэст-144, Санхүү төлөвлөлтийн хэлтэст-78, Тээвэр зохицуулалтын хэлтэст-86 албан бичиг ирж, нийт 306 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин 92,8%-ийн шийдвэрлэлттэй ажиллаж байна.

Ирсэн бичиг



(2025 оны жилийн эцсийн байдлаар)

Явсан бичиг



(2025 оны жилийн эцсийн байдлаар)

Явуулсан бичгийн шийдвэрлэлт нийт 310 үүнээс

- захиргаа хүний нөөцийн хэлтсийн 108. Хариутай 91 хариугүй 91 бичиг
- санхүү төлөвлөлтийн хэлтсээс нийт 147. Хариутай 12, хариугүй 135 бичиг
- тээвэр зохицуулалтын хэлтсээс нийт 55. Хариутай 6, хариугүй 49 бичиг

БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД ИРСЭН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

(2025.01.01-2025.12.23)

Байгууллагын хэмжээнд ирсэн бичгийн шийдвэрлэлт 2025 оны 01 дүгээр сарын 01-с 12 дугаар сарын 23-ныг хүртэл нийт 306 албан бичгээс хариутай албан бичиг 67, хариугүй албан бичиг 239 ирсэн байна.

Үүнээс: хугацаандаа шийдвэрлэсэн 278, хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 18, судалж байгаа 10 албан бичиг байна. Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь 98,8%-тай байна.

4.7.Байгууллагын архивын үйл ажиллагааны талаар

Байгууллагын даргадах Баримт нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнийг 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/15 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Байгууллагын захиргааны албан хаагчдаас 2025 онд хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын санал авч, 2025 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг байгууллагын даргадах БНШК-н хурлаар хэлэлцэж, байгууллагын даргаар батлуулсан.

2025 онд байгууллагын архивт 2024 оны ХХНДЖ-ын дагуу захиргаа хүний нөөцийн хэлтэс, тээвэр зохицуулалтын хэлтсээс цаасан суурьтай 85 баримтыг нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авав.

БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД ИРСЭН БИЧГИЙН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ



2024 оны байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гарсан 49, боловсон хүчний холбогдолтой 141, нийт 190 захирамжлалын баримтыг Нийслэлийн архивын www.arch.ulaanbaatar.mn программд шиеж цахим нөхөн бүрдүүлэлт хийсэн.





Нийслэлийн архивын газраас гаргасан хуваарийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн актаар цахим нөхөн бүрдүүлтийг хүлээлцсэн.

Байгууллагын архивт хадгалагдаж буй баримтыг данс бүртгэлийг Нийслэлийн Архивын газрын дэргэдэх БНШАЗК-ын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж данс бүртгэлээ батлуулсан.

Байнга хадгалах баримт, захирамжлалын цахим баримтыг 2025 оны 06 дугаар сарын 29-ний өдөр Нийслэлийн Архивын газрын Төрийн архивын хэлтэст байнга хадгалах баримт 190, захирамжлалын цахим баримт 19 (Hard) актаар хүлээлгэн өгсөн.

Нийслэлийн Архивын газрын БНШАЗК-ын хурлаар батлагдсан түүх эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны өч холбогдолгүй баримтыг устгах баримтын жагсаалтын дагуу байгууллагын баримт нягтлан шалгах комиссын хяналтан дор 2025 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 409 дүгээр нээлттэй, хаалттай хорих анги дээр 34 хэргийн 372 баримтыг устгасан.





(Угтаах хясаашилтын баяуу устгалт хийж байна)

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 23 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1220 дугаар захирамжаар төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн 2025 оны 3, 4 дүгээр улиралд зохион байгуулах болсон. Манай байгууллагын хувьд 2025 оны 11 дүгээр сарын 17, 18-ны өдрүүдэд архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт хамрагдаж 80,1% буюу хангалтайгаар үнэлэгдсэн.



4.8.Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдал



Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай болон Шилэн дансны тухай хуулийн хүрээнд төрийн үйлчилгээ, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг <http://baazweb.super-asia.net/> цахим хуудсанд, байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилт, гүйцэтгэл, тайлан мэдээ, Дотоод журам болон бусад дүрэм, журмууд даргын баталсан тушаал, тендерийн урилга, зар, санхүүгийн тайлан мэдээллийг тухай бүрт нь байршуулан ажилласан.



Байгууллагын фэйсбүүк дэх цахим хуудсыг нээж байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг www.baaz.ub.gov.mn, фэйсбүүк дэх page хуудас, байгууллагын дотоодын группт нийтлэн ажиллаж байна.



Мөн Шилэн ажиллагаа <https://shilen.gov.mn/home-д> 2, 3, 4 дүгээр улирлын нээлттэй мэдээллийг байршуулж тайланг илгээсэн.

ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ
АВТО БААЗ УТУГ-ЫН ДАРГА

ХЯНАСАН:
ЗАХИРГАА ХҮНИЙ НӨӨЦИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

НЭГТГЭСЭН:
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ, АРХИВ
БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН



Э.БОЛОР-ЭРДЭНЭ

М.БОЛОРМАА

Ц.ДЭЛГЭРМАА